

**БОЛОВСРОЛ СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН “ҮНЭЛГЭЭНИЙ БАГ”-ААС ТӨРИЙН
АЛБАН ХААГЧДЫН 2021 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГИЙН ҮНЭЛГЭЭНД ӨГСӨН ЗӨВЛӨМЖ**

2021.06.21.

Мандалговь

Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”-ын 4.4 дэх заалтыг үндэслэн 16 албан хаагчдын төлөвлөгөөний эхний хагас жилийн баталгаажуулсан тайлан, үнэлгээг байгууллагын үнэлгээний багийн гишүүн Боловсролын албаны Ахлах мэргэжилтэн болон Соёлын албаны ахлах мэргэжилтэн нарт журамд заасан хугацаа буюу 2021 оны 6 дугаар сарын 17-нд хүргүүллээ. Үнэлгээний багийн гишүүд Нэгжийн Даргын баталгаажуулсан тайлан буюу үнэлгээг хянаж, албан хаагчдын тайлан, үнэлгээг 2021 оны 6 дугаар сарын 20-нд баталгаажуулав.

Байгууллагын “Үнэлгээний баг” нь журмын 4.22 дахь заалтын дагуу байгууллагын үйл ажиллагааг ил тод мэдээлэх, гарсан алдаа дутагдал байвал арилгах, албан хаагчдын чадавхыг дээшлүүлэх зорилгоор дараагийн тайлант хугацаанд хэрэгжүүлэх зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Байгууллагын удирдлагад

- 1.1. Байгууллагын албан хаагчдын сэтгэл ханамжийн судалгааг удирдлага, зохион байгуулалтаар ханган оны эхэнд авч, саналыг тухайн оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг тооцон ажиллах
- 1.2. Төрийн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр харилцан туршлага солилцох, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх хэлбэрээр зохион байгуулах
- 1.3. Албан хаагчдыг ёс зүй, харилцааны ур чадварыг хөгжүүлэх сургалтад хамруулах
- 1.4. Байгууллагын “Үнэлгээний баг”-аас төрийн албан хаагчдын 2021 оны эхний хагас жилийн ажлын гүйцэтгэлд өгсөн үнэлгээг үндэслэн урамшууллыг тооцон олгох

2. Төрийн жинхэнэ албан хаагчдад

- 2.1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг байнга хянан, хэрэгжилтийг хугацаанд нь зохион байгуулах
- 2.2. Нэмэлтээр хэрэгжүүлэх арга хэмжээнд сургалтын хоцрогдлыг арилгах, сурлагын амжилтыг ахиулах, мэргэжлийн багш нартай баг болж, хамтран ажиллах ажлыг түлхүү оруулж хэрэгжүүлэх
- 2.3. Тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхээр баримт бичиг /Төлөвлөгөө, удирдамж гм/ боловсруулах тохиолдолд оны эхэнд буюу 1 дүгээр сард төлөвлөгөө, удирдамжийг боловсруулан нэгжид хүргүүлэх
- 2.4. Тайланд тусгагдсан тоо, баримт, үйл ажиллагааны үнэн бодит байдал, чанарт дүгнэлт хийх /нотлох баримт, баталгаажуулалт/
- 2.5. Мэргэжилтнүүд хамтын ажиллагаагаа сайжруулах, багаар ажиллах чадвараа хөгжүүлэх
- 2.6. Байгууллагаас зохион байгуулж буй арга хэмжээ, үйл ажиллагааг салбарын удирдлага, мэргэжлийн багш нар, олон нийтэд ил тод нээлттэй зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлэн ажиллах
- 2.7. Харилцааны ур чадвараа хөгжүүлэх /сургалтад хамрагдах/
- 2.8. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний болон бусад цаг үеийн ажлын тайлагналтын чанарт онцгой анхаарч, холбогдох дээд байгууллагаас болон байгууллагын удирдлага,

мэргэжилтнүүдээс өгсөн үүрэг даалгаврыг ажилтан бүр заасан хугацаанд нь заавал хэрэгжүүлж, өөрийн цагийн менежмент, төлөвлөх, зохион байгуулах чадвараа дээшлүүлэх

3. Төрийн үйлчилгээний албан хаагчдад

- 3.1. Жижүүрүүд байгууллагын гадна орчинг ээлж хүлээлцэхээс өмнө заавал цэвэрлэж, жижүүрийн мэдээллийн дэвтэрт бичиж тэмдэглэн хүлээлгэн өгч байх
- 3.2. Байгууллагын эд хогшлын эвдрэл, гэмтэл, бүрэн бүтэн байдлыг хариуцан ажиллах
- 3.3. Ажилчид улирал бүр нөөц боломжиндоо тулгуурлан санаачлан хийх бүтээлч ажлын төлөвлөгөө гарган батлуулж, хэрэгжилтийг тооцон ажиллах
- 3.4. Байгууллагын Нягтлан бодогч үйлчилгээний ажилтнуудыг өдөр тутам удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллах

4. Зөвлөмжийг хэрэгжүүлэх зохион байгуулалт

- 4.1. Байгууллагын төрийн албан хаагчдад “Үнэлгээний баг”-аас өгсөн зөвлөмжийг танилцуулж, дараагийн тайлант хугацаа буюу 2021 оны 2-р хагас жилийн нэмэлт ажлын хэсэгт тусган хэрэгжилтийг 2021 оны 12 дугаар сарын 10-ны дотор тооцон ажиллахыг Төсвийн Шууд захирагч болон нэгжийн даргад чиглэл болгов.
- 4.2. Төрийн албан хаагчид зөвлөмжинд тусгагдсан холбогдох заалтыг удирдлагуудаас өгсөн чиглэлийн дагуу санал, санаачилга гарган, хэрэгжүүлэн үр дүнг тооцон ажиллахыг зөвлөв.

ЗӨВЛӨМЖ БОЛОВСРУУЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ БАГИЙН ГИШҮҮН:

БСА-НЫ ДАРГА

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Л.ОЮУНБАЯР

Х.ЦОГЗОЛМАА

Ц.УРАНБЯМБА

ЗӨВЛӨМЖИЙГ ХҮЛЭЭН АВСАН: БСУГ-ЫН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР

ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ц.УРАНБЯМБА